

УЛС ТӨР

Дэлхийн банкны төлөөлөгчидтэй уулзлаа

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Жэймс Андерсон, тус банкны гишүүн байгууллага Олон улсын санхүүгийн корпорацийн суурин төлөөлөгч Туен Нгуен, төслийн удирдагч Д.Жигжидмаа болон үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир нарыг хүлээн авч уулзлаа. Сайд Ц. Мөнх-Оргил шинэ Засгийн газрын бүтэц, чиг үүрэг болон макро эдийн засгийн байдлыг тогтворжуулах, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Засгийн газраас төлөвлөж буй арга хэмжээний талаар Дэлхийн банкны төлөөлөгчдөд товч танилцуулсан юм. Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг хариуцсан газар Гадаад харилцааны яамны бүтэцэд ирсэн тул монголын экспортын бүтцийг төрөлжүүлэх, худалдааг хөнгөвчлөх болон олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт нэгдэх асуудлыг судлах зэрэг чиглэлд Дэлхийн банктай хамтран ажиллах боломжтой талаар сайд Ц.Мөнх-Оргил хэллээ. Харин Дэлхийн банкны төлөөлөгчид тус банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй төслүүдийн талаар сайдад мэдээлэл өгч, цаашид бус нутгийн эдийн засгийн интеграци, олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээ хийх үндэсний багийг сургах зэрэг асуудлаар хамтран ажиллах боломжуудыг нарийвчлан ярилцахаар тохиролцлоо.

М.ЭНХБОЛД: ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНААР МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СОНГУУЛИЙН ТӨСВИЙГ ЗАЙЛШГҮЙ ХЭЛЭЛЦЭХ УЧИРТАЙ



Ж.МЯГМАР

Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт ирэх дөрвөн жилд Засгийн газраас баримтлах бодлого, чиглэлийн талаар нэгдсэн ойлголт өгөх сургалт семинар өчигдөр Төрийн ордонд эхэллээ. Сургалт семинарыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат нээж, сургалт семинарын үйл ажиллагаанд Засаг дарга нарыг амжилттай оролцохыг хүслээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэцэд Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрыг байгуулсан. Энэ газрын ажилтнууд нутгийн удирдлагын чиглэлээр бүхий л асуудлыг хариуцаж, орон нутгийн удирдлагуудтай байнга холбоотой ажиллана гэдгийг тэрбээр тэмдэглэлээ. Тус газраас зохион байгуулж буй энэ арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд оролцож, өөрсдийн эрхэлсэн салбар, хүрээний асуудлаар 2016-2020 онд баримтлах бодлого,

зорилтын талаар орон нутгийн удирдлагуудад мэдээлэл өгч, ярилцах юм. Мөн зарим хууль тогтоомж, эрх зүйн орчны талаар салбарын эрдэмтэн судлаачид хичээл заана. Харин өнөөдөр 14:00 цагаас аймаг, нийслэлийн Засаг дарга нар Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулах багтамжид гарын үсэг зурах юм. Энэхүү багтамжаар Засаг дарга нар Ерөнхий сайдын өмнө тодорхой үүрэг хүлээж, түүнийгээ батламжлах болно. Мөн Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэхэд оролцож, саналаа хэлж, Монгол Улсын 2016 оны төсөвт хийх тодотголын талаар танилцуулга сонсч, улс орны төсөв, санхүүгийн өнөөгийн байдлын талаар мэдээлэл авах юм.

“Орон нутгийн удирдлага өөрт олгогдоогүй эрх хэмжээг бий болгосон”

УИХ-ын дарга М.Энхболд ирэх

дөрвөн жилд Засгийн газраас баримтлах бодлого, чиглэлийн талаар нэгдсэн ойлголт өгөх сургалт, семинарт оролцож буй аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нартай уулзлаа. Тэрбээр уулзалтын эхэнд эдийн засаг, нийгмийн хувьд амаргүй цаг үед ажиллах гэж байгааг онцолсон. Түүнчлэн “Долоо дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ-ын Анхдугаар чуулган зорилтоо амжилттай хэрэгжүүлээд өндөрлөсөн. Улсын баяр наадам, АСЕМ зэрэг олон чухал арга хэмжээ давхацсан ч Анхдугаар чуулганаар харьцангуй богино хугацаанд Засгийн газрыг эмхлэн байгуулж, УИХ Байнгын хороод, дэд хороодоо байгуулан, УИХ-ын дэргэдэх зарим байгууллагын удирдлагыг томилсон” гэв.

УИХ-ын дарга М.Энхболд, энэ долоо хоногийн сүүлээр УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан, тодорхой асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөж буйг уулзалтын үеэр мэдээлсэн. Энэ удаагийн ээлжит бус чуулганаар 2016-2020 оны Засгийн газрын

мөрийн хөтөлбөрийг баталж, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн үеэр ашиглах техник, хэрэгслийн талаар, сонгуулийн төсөв, зардлын талаар зайлшгүй хэлэлцэх учиртай гэж хэлэв. Тэрбээр “Өмнөх УИХ-аар хэлэлцэх ёстой байсан, хуулийн хугацаатай асуудлуудыг ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлан, 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018, 2019 оны төсвийн төсөөлөл, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг асуудлууд багтаж байгаа. Мөн Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаатай холбоотой хэд хэдэн хуулийн төсөл, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүдийг ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр төлөвлөдөг байгаа. Өнгөрсөн дөрвөн жилд

орон нутгийн удирдлага өөрт олгогдоогүй эрх хэмжээг бий болгон хууль зөрчсөн шийдвэр олныг гаргасан. Энэ асуудлыг онцгой анхаарч, хуульд нийцүүлэн засч залруулаарай” хэмээн аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт үүрэг болголоо. Ийнхүү орон нутгийн удирдлага эрх мэдлээ хэтрүүлэн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг шахаж дарамталснаас үүдэн гадны хөрөнгө оруулагчид буцах явдал гарч байсныг анхааруулсан. Энэ үеэр хууль зөрчсөн явдлыг засч залруулахын зэрэгцээ, иргэд хохирсон, эрх ашиг нь зөрчигдсөн байдалд хяналт тавьж, санхүүгийн хяналт шаалгалтыг ч зайлшгүй хийх шаардлагатай хэмээлээ. Эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд орон нутгийн удирдлага санаачилга гаргаж, хэмнэлт хийж ажиллах хэрэгтэй гээд УИХ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах болно гэж хэлсэн.

Онцгойлон анхаарч ажиллах салбарын тухайд тэрбээр “Боловсрол, эрүүл мэндийн салбарт онцгойлон анхаарч ажиллаарай. Орон нутагт энэ салбарыг удирдаж байгаа удирдлагуудын хүрээнд хариуцлагагүй байдал гарч байгаа. Энэ хоёр салбарт эдийн засгийн хүртээмж хүнд байгаагийн зэрэгцээ хүний хариуцлагагүйгээс болж ажил доголдож байгаа зүйл байгаа гэдгийг хэлмээр байна. Өдөр тутмын үйл ажиллагааны чиглэлийг өгч, үйл ажиллагаанд нь ойрхон байдгийн хувьд та бүгдийн анхаарлын төвд энэ хоёр салбар байж таарна. Хоёр, гурван хоногийн дараагаас сургууль, цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл эхэлнэ. Улаанбаатар хотод эхэлсэн. Энэ талаар хотын удирдлагуудтай ярилцсан. Наад зах нь бүртгэгч хүнд суртлыг нь багасгаж, байгаа нөөц боломжийнхоо хүрээнд бүртгэж аваад олон түмнийг бухимдуулахгүй энэ хоёр салбарын үйл ажиллагааг авч явах шаардлага зүй ёсоор тавигдаж байна” гэлээ.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн: **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар-Делигийн шууд нислэгт анхаарлаа хандуулахыг хүслээ

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай Бүгд найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Суреш Бабу уулзлаа. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Монгол Энэтхэгийн нөхөрсөг, ойр дотно харилцаа цаашид ч урт хугацаанд үргэжилнэ гэдэгт найдаж буйгаа илэрхийллээ. Мөн тэрээр “Монгол Улс санхүүгийн хувьд хямралтай байгаа ч, манай Засгийн газар улс орныхоо ирээдүйн хөгжлийг харсан, урт хугацааны тогтвортой эдийн засгийн бодлого хэрэгжүүлнэ. Уул уурхайн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээ түүхийгээр нь гадагш зөөдөг өнөөдрийн урсгалыг тодорхой хэмжээнд

хумьж, дотооддоо боловсруулж нэмүү өртөг шингээх нь манай улсын эдийн засагт их хэрэгтэй. Тийм учраас боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлд Энэтхэг улстай хамтарч ажиллахад бэлэн байна гэдгийг онцоллоо. Суреш Бабу Элчин сайдаар томилогдож ирээд удаагүй бөгөөд Монгол Улсад парламентын сонгууль нь шударга болж, ард түмний сонголтын үр дүнд тайван замаар засгийн эрх шилждэгийг нүдээр харж Монголын ардчиллаар бахархсанаа дурдлаа. Энэтхэг улсын Ерөнхий сайд Нарендра Модри өнгөрсөн оны тавдугаар сард Монгол Улсад айлчилсан. Энэ айлчлалын үеэр хоёр талын тохирсон зарим

асуудлыг хөндөв. Тухайлбал, Улаанбаатарт мэдээлэл технологийн төв байгуулах, Энэтхэг-Монголын хамтарсан сургууль байгуулах, Энэтхэгт сурах Монгол оюутны тоог тогтоосон хэмжээнд нь хүргэж сургах зэрэгт анхаарлаа хандуулахыг Элчин сайд хүслээ. Уулзалтын төгсгөлд, Элчин сайд, Монгол, Энэтхэгийн худалдааны эргэлт 15-20 сая ам.доллар байгаа нь хангалтгүй байна, хоёр улсын бизнесийнхний уулзалтыг тогтмолжуулах, иргэд харилцан зорчих зорилгоор Улаанбаатар-Дели-гийн чиглэлд шууд нислэг үйлдэх боломжтой эсэхэд анхаарлаа хандуулахыг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатаас хүссэн юм.



Э.МӨНХ

Эдийн засаг элгээрээ хэвтлээ, улс орны данс улайсан, цалин мөнгөө ч тавьж чадахгүйд хүрээд иргэд минь бүсээ чангалаад, тансаг хэрэглээгээ танаарай гээд байсан МАН-ынхан цаагуураа “тансаглаж” гарсан бололтой. Хамгийн эхний жиншээ, Хотын дарга С.Батболд. Тэрбээр экс хотын даргын суудаг байсан нэг давхрын жижиг өрөөг голж, Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтсийнхний суудаг байсан олон тасалгаатай өрөөг “өмчилж”, засвар хийлгэн, шинэ тавилгаар чимэн, музей шиг болгоод орчихжээ. Энэ өрөө нь ажлын өрөөнөөсөө цааш дамждаг хоёр өрөөтэйн дээр дотроо ариун цэврийн өрөөтэй гэнэ билээ. Түүний ийнхүү тансагласан зураг өчигдөржин

Алталсан өрөөнд Арабын шах шиг тухалчихжээ тэр...

сошиал ертөнцийн од боллоо. Э.Бат-Үүл Хотын дарга байхдаа ингэж өөрийнхөө өрөөнд анхаарч байсан удаагүй. Бүр яваад ороход ганц лед телевизор, хэдэн сандалнаас өөр юмгүй өрөөнд суучихаад л хотоо хөгжүүлэх гэж хараалган байж, их ажил хийж байсныг дурсах хүн олон байна. Гэтэл хүмүүсээ хална, зардлаа танана гээд л сүржигнээд байгаа УИХ-ын экс гишүүн, шинэхан хотын дарга маань өөрөө харин Арабын шах шиг тухлахаар шийдсэн бололтой. Тэрбээр ажилчдынхаа ордог ариун цэврийн өрөөг ч ашиглах сонирхолгүй байгаа нь илт. Энэ ч яамай, сонгууль өнгөрөөд хоёр сар болж байхад хотод нүдэнд харагдаж, гарт баригдах ажил хийв үү, тэд. Үнэндээ өрөөний сайхан өнгө төрх ажилд нэмэр болдог бол ирэх дөрвөн жилд С.Батболд дарга Арабын Дубай шиг хотод биднийг амьдруулах бололтой дөг шүү. Ерөөл бат оршиг л гэхээс дээ.

Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлогыг өргөн барина

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохионд тавих техникийн шаардлага, хэрэглэх дүрмийн үндэсний стандартыг шинээр боловсруулах, Төрөөс автотээврийн талаар баримтлах бодлогыг УИХ-д өргөн барих санал гаргалаа. Түүнчлэн “Чингис хаан” нисэх буудалд үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн эмх замбараагүй үйл ажиллагааг цэгцэлж, олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулах боломжийг судлахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосон байна. Тэрбээр сайдын өмнөх шуурхай хуралдаанаараа Автотээврийн тухай, Авто замын тухай, Иргэний нэвсгийн тухай хуулиудыг шинэчлэн, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах санал гаргасан. Мөн өмнөх хуралдаанаар зам барихдаа чанар, стандарт зөрчсөн аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох болсон. Энэ хүрээнд зам барилгын ажлын алдаатай болон өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа зураг төслийн жагсаалтыг гаргажээ.

Дүүргүүдийн сонгуулийн хороог байгуулав

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор дүүргүүдийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах нийслэлийн Сонгуулийн хороог байгуулсан байна. Нийслэлийн Сонгуулийн хорооны даргаар нийслэлийн ЗДТГ-ын Нутгийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга У.Ганболд, гишүүдэд нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч дарга Т.Батдорж, нийслэлийн Архивын газрын дарга С.Гаваа, нийслэлийн Хөдөлмөрийн газрын орлогч дарга Б.Мөнхцэцэг ажиллаж байгаа аж.

Харин нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Ч.Авирмэд, Дотоод аудитын албаны Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, Хуулийн хэлтэст Д.Баялагцэнгэл, Санхүү, төрийн сангийн хэлтсийн Б.Норжинлхам, Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Октябрь нар ажиллахаар болжээ. Нийслэлийн Сонгуулийн хорооны тогтоолоор дүүргийн ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулах дүүргүүдийн Сонгуулийн хороог байгуулсан аж. Тухайн дүүргийн хурлын сонгуулийг шууд удирдан зохион байгуулж, сонгуулийн хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг дүүргүүдийн Сонгуулийн хороодод үүрэг болгожээ.

ҮЗЭЛ БОДОЛ



РИОГИЙН ДЭВЖЭЭ

МОНГОЛЫН ТАМИРЧДАД ХАТУУ БАЙЛАА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тэр дундаа топ дөрвөн төрлөөсөө ихийг хүлээсэн нь тодорхой. Харамсалтай нь хүлээлтэд нийцэхээр хэмжээнд оролцож чадсангүй. Бээжин болоод Лондоны Олимпын наадмын амжилтдаа хүрсэнгүй, манайхан. Хамаагүй олон тамирчин илгээсэн. Дээрээс нь дөрвөн жилийн циклд Монголын тамирчид дэлхийд хамгийн хүчтэй өрсөлдөгч гэдгээ харуулж байсан байж шүү дээ. Яахав, 2000 онд хоосон, 2004 онд ганц хүрэлтэй ирж байсны дэргэд бол дажгүй. Гэхдээ л нэг үеэ бодвол тамирчдын чадвар чансаа дээшилсэн энэ үед иргэдийн хүлээлтэд хүрэх хэмжээнд байж чадаагүй нь Монголын ард түмний бухимдах шалтгаан болчихоод байгаа юм. Нөгөө талаар улс орныхоо өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлахгүй, хэт үлбэгэр барилдаж байна гэх ч шүүмжлэл өрнөж, иргэд тамирчдаа өмөөрөх, шүүмжлэх хоёр хэсэгт хуваагдчихаад байгаа юм. Гэхдээ Монголын тамирчид муу оролцоно гэж Риод очоогүй нь тодорхой. Маш олон шалтгаан нөхцөл байгаа.

Чамлах уу, чанга атгах уу

Риогийн Олимпын наадамд 200 гаруй орон оролцсоноос ердөө 87 нь ямар нэг байдлаар медаль хүртлээ. Португал, Арабын нэгдсэн Эмират улс, Австри гэх мэт хөгжсөн, эдийн засаг сайтай орнууд гэхэд л ердөө ганцхан хүрэл медаль авлаа. Хүн амынхаа тоогоор дэлхийд хоёрдугаарт орох Энэтхэг улс гэхэд манайхтай адилхан нэг мөнгө, нэг хүрэл медаль авсан. Ингээд бодвол бид авсан хоёр медаль чамлах ёсгүй. Харин ч чанга атгах ёстой юм биш үү. Нөгөө талаар Олимпын наадам Өмнөд Америк тивд болсон нь манайханд тодорхой хэмжээнд нөлөөллөө. Бээжинд Олимпын наадам болоход манай тамирчид хоёр алт, хоёр мөнгө хүртсэн. Хэн ч найдаагүй Н.Түвшинбаяр аварга болчихоод зогсч байлаа шүү дээ. Э.Бадар-Ууган бол Монголын боксын спортод гарч ирсэн тод од. Түүнд алтаас өөр медаль тэр үед харагдаагүй. Дээрээс нь цагийн зөрүү, цаг агаарын байдал нөлөөлсөн байх талтай. Тэгвэл Лондоны Олимпын наадмаас хоёр мөнгө, гурван хүрэл, нийт таван медаль хүртсэн. Цагийн зөрүү Риог бодвол арай бага. Тийм болохоор чанараар Бээжинг гүйцээгүй ч тоогоор давсан. Энэ удаад бол цагийн зөрүү, тухайн орны цаг агаар, бүхий л нөхцөл байдал манайд тийм ч таатай байгаагүй гэдгийг бодолцох хэрэгтэй. Гэхдээ л дэлхийн том мэргэжилтнүүдийн хэлж байсанчлан Д.Сумъяа финалда чадлаа. Түүнийг түрүүлнэ гэж байсан ч хараахан чадсангүй. Мөн тооцоонд байсан Д.Отгондалай медальд хүрсэн. Тийм болохоор хэдэн тамирчнаа хэтэрхий гоочилж, элдвээр хэлж, харааж зүхэхээ азная. Тэд хоосон гуяа ганзаглаад ирээгүй, хоёр медаль аваад ирсэн. Дээрээс нь манай тамирчдыг медаль авахад ямар олон шударга бус зүйл, буруу шүүлт хаалт, тээг болов гэдгийг ч бид харсан шүү дээ.

Нэг алт, нэг мөнгө, нэгжээд хүрэл авах боломж байлаа, даанч шүүлт...

Тамирчдынхаа амжилт гаргаж чадаагүйн бурууг бусад руу чихэх гэлээ

гэж битгий бодоорой. Олимп үзсэн хүн бүр мэдэж байгаа. Шүүлтийн асуудал манай тамирчдыг “алсан” гэдгийг зүгээр л хүлээн зөвшөөрчих. Шүүгчтэй нь хамт найдвартай ялах хэрэгтэй л дээ, уг нь. Гэхдээ бас дэлхийн шилдгүүд хоорондоо “үзэж” байхад заримдаа илт давуу ялах хэцүү шүү дээ. Яг энэ үед л шүүгчдийн ур чадвар, шударга шүүлт хэрэгтэй. Жүдогийнхоос авахуулаад л бид үзэмж харсан шүүлтийн горьг амссан. Д.Сумъяа таамаг ёсоор алт авах байлаа. Гэвч Бразилын бөх тохойгоороо тахимдад л ялчихлаа. Нөгөө шинэчилсэн дүрэм энэ тэр хаана байгаа юм. Тухайн үеийн барилдаанд тааруулаад л дүрмээ тайлбарлачихсан. Г.Одотгондалай дээр гэхэд л Америкийн тамирчин илт муу барилдаж байхад торгохгүй байсаар байгаад л дуусгасан. Бокс дээр яав. Д.Отгондалай эхний үед биш юм гэхэд сүүлийн хоёр үе дээр илт илүү байж, өрсөлдөгчөө зодсон. Гэтэл Францын тамирчинд ялалт өгөөд л дуусгасан. Бокс дээр энэ мэт булхайтай шүүлт хэд хэд гарч, зарим тамирчин нь бүр шүүгчид дунд хуруугаа гозойлгосон. Шүүлтийн асуудал ганцхан манайд тохиолдоод байгаа юм биш. Дэлхийн том улсууд хүртэл аргаа барж байна. Хамгийн сүүлд Г.Мандахнаран дээр яав. Бүгд л мэдэж байгаа. Гэтэл Олон улсын боксын холбоо, Дэлхийн бөхийн холбоо хэдэн шүүгчээ хөөсөн нэр зүүгээд л үлдлээ шүү дээ. Ганцхан манай тамирчид луйвардуулчихлаа гээд ялагдлаа бусад тохоод байгаа бол яахав. Гэтэл бусад орнууд ч гэсэн аргаа барж, тамирчид нулимсаараа “нүүрээ угааж” байгааг хэн хүнгүй л харсан байх. Хэрвээ жаахан шударга шүүсэн бол бидний хүсч байсан алт, мөнгө, хүрэл медалийг хэд хэдийг авчих боломж байсан уу гэвэл байсан юм шүү.

Дэлхийн том гүрнүүд бидэнд дургүйлхэв үү

Бас л нэг асуулт. Д.Сумъяаг ялагдахад монголчууд үнэхээр бухимдсан. Булхайтай шүүлт байлаа

гээд. Яг үнэндээ булхайтай байж болохоор л шүүлт. Тийм болохоор ард түмэн бухимдах эрхтэй. Алтан медаль авсан бол ямар сайхан байх билээ, тийм биз дээ. Гэтэл энэ дургүйцсэн байдал Олон улсын жүдо бөхийн холбооныхны дургүйг хүргэчихсэн байж магадгүй хэмээн зарим хүмүүс үзэж байна. Цаашлаад боксын тэмцээнүүд дээр дургүйцээ илэрхийлсэн нь ч нэмэр болсон байж ч болох. Ингээд л чөлөөтийн шүүлт дээр манай Г.Мандахнаранд хатуу хандав уу даа. Ийм гаргалгааг олон хүн хийж байна. Уг нь бол чөлөөт чин чөлөөтэй л барилдах ёстой бөхийн төрөл. Чөлөөтэй довтолж, чөлөөтэй мэх хийж, чөлөөтэй хамгаалдаг. Барилдаан дуусахад хэдхэн секунд дутуу байхад зугтаж хамгаалах, гарга оргох бол байх л асуудал. Яагаад гэвэл чөлөөт бөх шүү дээ. Үүнийг ганц нэгхэн хүн хэлээд байгаа юм биш. Чөлөөт бөхөөр насаараа хичээллэсэн хашир бурхинууд ч энэ бол улаан цагаан луйвар гэдгийг хэлж байна. Тийм болохоор бидний гомдол тэдний дургүйг хүргэж гэж л дүгнэхээс өөр яалтэй билээ. Дээрээс нь Орос манай хоёршүүгччөөд, бааханбужигнуулсан талаар хойд хөрийнхон одоо болтол ярьж байгаа, худалч хүнд. Сүүлдээ энэ асуудал Путины хэмжээнд хүрсэн талаар ч сайтууд мэдээлж байна. Энэ холион бантан нь Олимпын дэвжээн дээр манай бөхчүүдэд нөлөөллөө гэх ч хүн байгаа юм. Орос том гүрэн. Дэлхийн бөхийн холбоо тэд бараг л атгаж байгаа. Энэ тохиолдолд дээрх гаргалгаа хол зөрөхгүй ч байж мэднэ.

Тактик, тактик, бас дахин тактик

Дандаа л тамирчдаа өмөөрнө гэж бас юу байх билээ. Манайханд дутуу зүйл их байна. Тухайлбал, ямар ч тактикийн барилдаан хийхгүй байгаа нь харагдлаа. Цагийн төгсгөлд оноо, үнэлгээ алдаж, атгаж байсан медалийнхаа оосрыг алдсан харамсалтай тохиолдол хэд гарав даа. Харин үүний учрыг Х.Цагаанбаатар

гавьяат тайлбарласан байсан. Тэрбээр “Монгол Улсад өнөөдрийг хүртэл спортын сэтгэл судлалаар доктор хамгаалсан хүн байхгүй. Тамирчны сэтгэл зүйн тал дээр ажилладаг баг байтугай хүн ч байхгүй. Байгаа хэд нь ерөнхий сэтгэл судлалаар доктор хамгаалсан хүмүүс байдаг. Тийм болохоор тамирчид нь яаж сэтгэл зүй өндөр байх билээ дээ. Тамирчдад сэтгэл зүйч хэрэгтэй. Аливаа спорт ялангуяа одоо цагт шинжлэх ухааны үндэсгүй бол явахгүй. Эрдэм шинжилгээний баг гэж өндөр түвшинд судалдаг судалгааны баг байх ёстой.

Гэтэл манайд байгаа, Эрдэм шинжлэгээний баг яг юу хийгээд байдгийг би ойлгодоггүй юм. Миний мэдэхийн Афин, Бээжин, Лондон, Бразил гэх мэт дөрвөн Олимпын циклд лав юу ч хийсэнгүй. Олимпод яваххаас 10-н хоногийн өмнө ирээд 10 секундээр хурд авахуулж, зүрхний цохилт тоолчихоод л явдаг. Энэ эрдэм шинжилгээ судалгаа юу. Эрдэм шинжилгээ судалгаа гэж арай өөр зүйл баймаар юм” хэмээн бичсэн. Энэ мэт олон шалтгааныг тэр бичсэн байна билээ. Үнэн, яах аргагүй үнэн. Гэхдээ сэтгэл зүйгээс гадна манайд тактикийн барилдаан гэж алга. Дасгалжуулагчдын баг ч гэсэн муу ажиллалаа. Гавьяат, дэлхийн аварга М.Уранцэцэг торгуулаар ялж яваад сүүлийн хэдхэн секундэд үнэлгээ алдаад ялагдсан. Чөлөөтийн бараг бүх тамирчид цагийн төгсгөлд оноо алдаж, үнэлгээгээ хамгаалах тал дээр хангалтгүй ажиллалаа. Оноо илүү явж байж өөрсдөө дутуу мэх хийж, алдаа гаргасан чөлөөтийн тамирчин 2-3 байлаа. Мөн оноо илүү явж байгаад сүүлийн 20 гаруйхан секундэд оноо алдсан бөх ч 2-3 байлаа. Эцэст нь Г.Мандахнаран яав. Цаг дуустал барилдаад л зогсч байх хэрэгтэй байсан шүү дээ. Луйвардуулах үндсээ бид өөрсдөө л тавьж өгөөд, тэдэнд боломж гаргаад өгчихлөө. Ийм л байна. Гэхдээ юм нэгээр дуусахгүй, дараа дараачийн тэмцээн, Олимпын наадамд алдаагаа засаад орж ирэх байх. Гэхдээ Токиогийн Олимпын наадам ч хол байна даа.

Дугаарын **60** мөр

Улсын нийслэл хөгжих гээд байна уу, мөхөх гээд байна уу

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Харин одоо ад шоо үзэх зүйлгүй болцгоон зам, барилгын ажлууд таг зогсч. Үзээд өгье ч сум нь хөдлөн ажиллаж байгаа цамхагт кран Монгол Улсын нийслэлийн зургаан дүүрэгт алга. Зуны бороо усанд идэгдэж, цөмөрсөн зам нь арзайгаад л. Түүн дээгүүр харайлгасан жолооч нар хараалаа урсгаж дуусч буй. Дүүрэн зорчигчтой автобус онгойж харлах нүхэн дээгүүр хэд харайлгаад л тэнхлэг нь хазайж, дугуй нь хагараад жагсаалаас гардаг юм гэнэ лээ. Түүнийг нөхөж завсарлах үүрэг бүхий Хот тохижуулах газар гэж уг нь байдаг л байлтай. Бодвол дарга цэрэг нь солигдоод хайхрах эзэнгүй болсон юмдаг уу даа. Өглөө бүр ниймэрхүү өнгө төрхтэй гундмал, гандмал нийслэлийн гудамжаар алхахаар сэтгэл дагаад бүх зүйл хоосон мэт санагдаад явчих юм. Заримдаа “Дулмаа минь л бодогдоод байх юм” гэдгээр өөрийн эрхгүй өнөө муу Үүлийгээ үгүйлээд эхлэх юм гээч. Бурхан болчихсон биш дээ, яаж ийж байгаад ирэх дөрвөн жилийн тэсчихвэл ч учир нь олодох байх, улаанбаатарчууд буруу сонголт хийсэн гэмээ ухаарна хэмээвч цаг хугацааг дэмий алдаж буй гэж бодохоор тогтож суух газраа олж ядах юм. Үүнд бид өөрсдөө буруутай. Ухаан зараад нийслэлийнхээ удирдлагуудад итгэл үзүүлсэн бол АН-ын эхлүүлсэн “Гэр хорооллын барилгажилт”, “Сайн хашаа” мэтийн төсөл хөтөлбөрүүд үргэлжлээд зогсохгүй улаанбаатарчууд хэдэн зуун модон жорлон, утаа саагнуулах яндангаасаа салах байлаа. Хэдхэн хоногийн дараа гэр хорооллынхон утаагаа үйлдвэрлээд эхэлнэ. Тэр цагт л бүхнийг ойлгох байх даа. Уг нь дээрх хөтөлбөрүүдийг АН нийслэлийн төсөвт дарамт болохгүйгээр иргэн, банк, аж ахуйн нэгж гурвын харилцан ойлголцол, гурвалсан гэрээгээр шийдэх боломжийг бүрдүүлж өгсөн хэрэг.

Өнөө өглөө гэхэд л хотын төв гудамжинд хэзээ нурж, хэн нэгнийг алах бол гэмээр том том самбарууд шил дараад босчихож. Зар сурталчилгааны самбарууд чухамдаа мөнгийг цагаар хүүлдэг юм гэнэ лээ. Мэдээжийн хэрэг тэрхүү самбар хэн нэгэн ядарсан иргэнийг биш. Хотын удирдлагуудад нөлөөлж чадсан бизнесмений өмч нь ойлгомжтой. Түүнчлэн ирэх долоо хоногт хичээлийн шинэ жил эхэлнэ. Иргэдийн ихэнх нь хөдөө гадаа явсан амралтын хоёр сард нийтийн тээврийн үйлчилгээг зохицуулж чадахгүй байгаа нийслэлийн өнөөгийн удирдлагууд хичээл сургууль эхлэхээр яах юм бол. Төрөөс мөнгө нэхээд сууж байдаг нийтийн тээврийнхэн угжныхаа мөнгөнд цадчихаад үдшийн 22 цагтай уралдаад баз руугаа урагдаад алга болдог болжээ. Аргаа барсан иргэдийг хэд гурваараа нийлэн таксидэх эсвэл микродох гэсэн хоёр боломжийг хүлээж буй. Микронд зогсоогоороо зорчих ч энүүхэнд болсон гэнэ лээ. Бас нэг хэлэх зүйл бол иргэдийн талархлыг зүй ёсоор хүлээж байсан нэг цэгийн үйлчилгээ эдүгээ ор нэр төдий болсон байна лээ. Ихэнх нь ээлжийн амралтын эдэлж буй гэж байгаа ч чухамдаа 2012 оноос хойш төрийн албанд ажилд орсон төрийн үйлчилгээний ажилтнуудыг цомтго гэсэн МАН-ын даргын тушаалд хамрагдчихаад мэдэгдэл ирэхийг хүлээж байгаа маргаашийн ажилгүйчүүд аж. Ингэхээд бодохоор Монгол Улсын нийслэлд болж бүтэж байгаа зүйл алга мэт. Зул бохогийнхоо өмнө бадмалдаг гэдэг шинг хот маань мөхөхийн өмнө маш богино хугацаанд хөгжсөн юм биш байгаа. С.Батболд дарга УИХ-д хэдэнтээ сонгогдохдоо төрж өссөн Төв аймгаа хөгжүүлж чадаагүй билээ. Тийм хүн улсын нийслэлийн хөгжлийг тодорхойлж, сая илүү хүн амтай их хотын иргэдийг хоногийн хоолтой, бусдын царай харуулалгүй авч явна гэдэг нь юу л бол. Эргэлзэж л байна шүү.

MMINFO

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATA PLAY STORE TATA APP STORE

УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Б.БАТХУЯГ: СЕХ-НЫ УДИРДЛАГУУД ЗАХИРГААНЫ АКТ ГАРГАХ ЖУРМААР СОНГУУЛИЙН ДҮНД НӨЛӨӨЛСӨН ГЭЖ ҮЗЭЖ БАЙГАА



талаар гомдлууд гарсаар байгаа. Өнөөдөр дээд болон хяналтын шатны шүүхээс шийдвэрүүд гарчихсан байна. Тухайлбал, Орхон аймгийн хяналтын шатны шүүхээс 29 нэр дэвшигчийг дахин сонгуульд өрсөлдүүлэхээр шийдвэр гарчихаад байгаа. Шүүхийн шийдвэр нэгэнт гарсан учраас СЕХ, аймаг орон нутгийн удирдлагууд, сонгуулийн хороонд хандаж, дахин сонгууль явуулах шаардлагыг тавина. Мөн Дархан-Уул аймагт 15 нэр дэвшигчийг бүртгээгүй улмаас Дээд шүүхийн шийдвэр гарч, дахин сонгууль

орон нутагт гарсан гомдолтой зөрчлүүдийг бид цаг тухайд нь мэдээнэ. Бид мөн СЕХ-ны удирдлагуудтай холбоотой асуудлуудыг танилцуулж байсан. Энэ гомдлуудыг одоо нэгтгэж дахин дахин ТЭГ болон АТГ-г гаргаж өгөх болно.

“Чухам ямар хууль бус үйлдэл гаргасан гэж үзээд байгаа юм бэ?”

“СЕХ-ын удирдлагууд захиргааны акт гаргах журмаар сонгуулийн дүнд нөлөөлсөн гэж бид үзэж байгаа. Жишээлбэл,

акт гаргачихсан. Үүнийг бид СЕХ-ны удирдлагууд сонгуулийн дүнд нөлөөлөх гэсэн арга хэмжээ байсан гэж үзэж байгаа юм. Бидэнд УИХ-ын болоод аймаг, нийслэлийн ИХ-ын сонгуулийн үеэр хууль зөрчсөн үйлдэл гаргасан талаарх гомдол маш их ирж байгаа. Өнөөдрийн байдлаар 450 орчим гомдол ирчихээд байгаа. Бид энэ гомдлуудыг цэгцлээд, хууль зөрчсөн нотолгоотой баримтуудыг энэ мэтчилэн мэдээлж байх болно.

“Өмнө танай намаас энэ билчлэг үнэн бодит байна аа гэсэн дүгнэлт Шүүхийн шинжилгээний хүрээлэнгээс гарсан гэж мэдээлж байсан. Гэтэл одоо болохоор прокуроорос хуурамч гээд мэдэгдчихлээ шүү дээ. Одоо давж заалдах боломж байгаа юм уу?”

“Нийслэлийн прокуроорос гаргасан шийдвэрт хуульд заасан гомдол гаргах эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй. Тийм болохоор бид хуульд заасны дагуу дээд шатны прокурорт гомдлоо гаргана. Билчлэгийг эвлүүлэг биш гэж үзсэн Шүүх шинжилгээний албаны дүгнэлтийг эцсийн байдлаар гаргаагүй байгаа. Бид гомдол гаргах явцдаа Шүүх шинжилгээний байгууллагын эцсийн дүгнэлтийг гаргаж танилцуулах болно.

“Танай намаас хууль хяналтын байгууллагад хандлаа л гэдэг. Гэвч хууль хяналтын байгууллагаас эрх баригчдад үйлчилсэн шийдвэр гаргаад байгаа юм биш үү. Дахиад хуулийн байгууллагад хандаад, өнөөх л эсрэг шийдвэрүүд гарвал цаашид яах вэ?”

“Сонгуулийн үеэр болон дараа

нь намайг намын гишүүд, нэр дэвшигчдийн гаргасан өргөдөл гомдолд бид маш нухацтай хандаж, хууль хяналтын байгууллагад өгч байгаа. Цагдаагийн байгууллага, шат шатны шүүхэд хандсан. Гэтэл хууль хяналтын байгууллагууд өрөөсгөл дүгнэлт хийж байгаа талаар манай гишүүд маш олон гомдол санал ирүүлж байна. Ирж байгаа тэр материалуудыг нэгтгэж үзээд, хууль хяналтын байгууллагуудын албан хаагчдын нөлөөлөл байгаа эсэхийг тодруулж байгаа. Хэрвээ байвал багцдаад гомдол гаргах чиглэлийг барьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ямар нэг хууль хяналтын байгууллагын ажилтан ийм нөлөөллийн улмаас хэрэг шийдэхэд оролцсон байна гэсэн нотолгоо алга. Гэхдээ хүмүүсийн ирүүлсэн гомдлыг нэгтгэж ажлыг хийж байна.

“Сүхбаатар аймгийн Захиргааны хэргийн шүүхээс АН-ын талд шийдвэр гаргасан гэсэн. МАН-ынхан давж заалдсан юм болов уу. Энэ талаар мэдээлэл өгөөч?”

“Сүхбаатар аймгийн сонгуульд хоёр намаас нэр дэвшигчид адил 16 суудал авсан. Нэг нэр дэвшигчийн асуудал маргаантай үлдсэн. Энэ нэр дэвшигчийн асуудлыг дахин сонгууль явуулж шийдэх ёстой байсан боловч Сүхбаатар аймгийн МАН-ынхан хуралдаад, хууль бус шийдвэр гаргаад явчихсан. Өнөөдөр Сүхбаатар аймгийн АН шүүхэд гомдол гаргаад, ялалт байгуулсан. Цаашид Сүхбаатар аймгийн МАН-ынхан гомдол гаргах эсэх нь тэдний эрхийн асуудал учраас бид хараахан хэлж мэдэхгүй байна. Одоохондоо бол гомдол гаргаагүй байгаа юм билээ.

...Сүхбаатар аймгийн сонгуульд хоёр намаас нэр дэвшигчид адил 16 суудал авсан. Нэг нэр дэвшигчийн асуудал маргаантай үлдсэн. Энэ нэр дэвшигчийн асуудлыг дахин сонгууль явуулж шийдэх ёстой байсан боловч Сүхбаатар аймгийн МАН-ынхан хуралдаад, хууль бус шийдвэр гаргаад явчихсан...

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Намын санхүүжилт босгохоор ярилцаж байгаа 60 тэрбумын асуудлыг ярьж байгаа бичлэг цацагдсаны дараа нийслэлийн МАН-ын дарга “Дотроосоо мэдээлэл алдсан этгээдийг бид хайж байгаа. Намын дотоод асуудлыг гадагш нь алдсан байна” хэмээн мэдээлэл хийж, энэ гэмт хэргийг хүлээн зөвшөөрсөн. Тийм байтал Нийслэлийн прокурор энэ

хэргийг хэрэгсэхгүй болгосонд гомдолтой байна. Энэ асуудал цаашид шалгагдаад явах байх. Бид хуульд заасан үндэслэлээр зохих газарт нь гомдлоо гаргаж байгаа.

“Сонгууль будилаантай болсон гэсэн гомдол маш их ирж, шүүхийн шийдвэрүүд гарсан гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөөч?”

“2016 оны УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль будилаантай болсон

явуулахаар болсон. Та бүхэн сайн мэдэж байгаа байх. Сүхбаатар аймгийн Иргэдийн хурал хууль бус шийдвэр гаргасан талаар бид мэдээлсэн. Тэгвэл анхан шатны шүүхийн шийдвэр гарч, сонгуулийн эцсийн дүн гараагүй байхад аймгийн Иргэдийн хуралд хуралдсан нь хууль зөрчсөн үйлдэл байна. Мөн аймгийн Иргэдийн хурал хуралдаж, Засаг даргыг томилсон гэх мэт зургаан тогтоолыг хүчингүй болгосон. Энэ мэтээр цааш цаашид

саналын хуудсыг сонгогчдын тоогоор 21 аймаг, есөн дүүрэгт бүрэн хүргэсэн гэж чиг үүргийн удирдлагууддаа мэдэгдсэн байдаг. Гэвч бодит байдал дээрээ зарим газарт саналын хуудсыг 80 орчим хувьтай л хүргэсэн. Түүнээс гадна саналын хуудас дутсан газруудад саналын хуудсыг хэвлэж авах захиргааны акт гаргасан байж байгаа. Ингээд саналын хуудсыг хэвлэж эхэлсэн. Гэвч саналын хуудас хэвлэх ажиллагаа нь буруу байна гэсэн

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 08 сарын 22-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: ӨУХ16/002

“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ нь эрх бүхий эрх бүхий тендерт оролцогчоос Баянзүрх, Хан-Уул, Багахангай дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Багц 02-01 Хонины мах
Багц 02-02 Үхрийн мах
Багц 02-03 Төмс, хүнсний ногоо

Тендерт оролцогчид:

- Сүүлийн нэг жил буюу 2014-2015 оны санхүүгийн тайлан
- Ижил төстэй бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг гүйцэтгэсэн туршлагын талаар мэдээлэл ирүүлэх
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших юм үү үл хөдлөх хөрөнгийн баталгаажсан гэрчилгээ эсхүл түрээсийн гэрээний баталгаажсан хуулбар
- Тендерт оролцогч тухайн багц бүрт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 09 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 минутас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 09 дугаар сарын 22 –ны 11.00 минутанд нээнэ.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөгөөр худалдан авна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 19 дугаар хороо, 16-р хороолол
“Өсвөр Үе Хүнс” ОНӨААТҮГ-ын өөрийн байранд
Б.Хулан 99294200

Төлөр хийх хэлбэр: Дансаар тушаана
Банкны нэр: Улаанбаатар хотын банк
Дансны дугаар: 2611077920

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016-08-23
Тендер шалгаруулалтын нэр: СХД-ийн цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер 2016-Б/002 - Багцалсан
Тендер шалгаруулалтын дугаар: 2016-Б/002

“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ нь эрх бүхий тендерт оролцогчоос Сонгинохайрхан дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2016 оны хагас жилийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн багц бүрт санал болгож буй үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх тендерийн баталгааг ирүүлэх

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр /сахимаар/ нь 50,000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Тендерт оролцогчийн сүүлийн нэг жил /2015 он/-ийн борлуулалтын орлого нь санал болгож байгаа үнийн дүнгийн 40%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн 40 %-аас багагүй байх**
Баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2014 он 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Санал болгож буй үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна. /2014 он 2015 он/**
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2014 он 2015 он/**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тендерийн баримт бичигт дэлгэрэнгүй тусгасан болно.**

Тендерийг 2016 оны 09 дугаар сарын 22-ний 09:30 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 09 дугаар сарын 22-ний өдрийн 10:00 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Монгол улсын гарал үүсэлтэй бараанд дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Төлбөр хийх хэлбэр: Дансаар тушаана
Банкны нэр: **Голомт банк**
Дансны дугаар: **1205024548**
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБ хот. Сонгино хайрхан дүүрэг 18-р хороо, Авто тав ХК-ний байр
Утас: 9703-2420, 99069416

ОНЦЛОХ ХУУДАС

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛ, ДАВАН ТУУЛАХ ГАРЦ...

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт



Н.Дашзэвэг:
Манай эдийн засаг дампуурлынхаа зам руу орчихсон

/МУ-ын гавьяат эдийн засагч, Эдийн засгийн ахлах сургуулийн захирал/

-Монголын эдийн засгийг дампуурчигдсан байна гэж хэлж болно.Төсөвмашинхалдалтай гарлаа, улсын валютын нөөц үндсэндээ шавхагдчихсан, гадны зээлээр валютын нөөцөө бүрдүүлээд явж байна. Ирэх онд өрөө төлөх мөнгө байхгүй байна. Мөн манай эдийн засгийн өсөлт оны эхэнд 1.3 хувьтай гарчихлаа. Төгрөгийн ханшийн уналт тасралтгүй нэмэгдэж байна. Ажилгүйдэл нэмэгдэхийн зэрэгцээ ядуурал дагаад нэмэгдэж байна. Энэ мэтчилэн эдийн засаг маш олон төрлийн өвчинд баригдчихсан байна. Банкны систем,

Төвбанк, улсын төсөв гээд бүгд өвчилчихлөө. Дараа жил өрөө төлж чадахгүйн улмаас хугацааг нь хойшлуулах, эсвэл дахиж зээл авч тал хагасыг нь ч болов хаах арга хэмжээ авах нь тодорхой байна. Дээрээс нь Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд нар хамаг далан булчирхайгаа тоочоод, гадны хөрөнгө оруулагчид Монголыг сонирхох байдал нь үндсэндээ хаагдчихлаа. Ийм дампуу төсөвтэй, төгрөгийн ханш нь ганц хоёрхон сарын дотор 150-200 төгрөгөөр нэмэгддэг оронд хэн ч хөрөнгө оруулахгүй шүү дээ. Мөн манай улсын зээлжих зэрэглэлийг олон улсын үнэлгээний байгууллага өчигдрөөс эхэлж буулгаад В- болгочихсон байна. Тэгэхээр манай эдийн засаг дампуурлынхаа зам руу орчихжээ л гэж харж байна.

Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь тодорхой хэмжээнд зөв байх. Тэгэхдээ нөгөө талаар эдийн засгийн

өсөлт нь 1.3 хувьд хүрчихсэн, ажилгүйдэл нь 10 хувиас дээшгээ гарчихсан байгаа энэ асуудлыг яаж шийдэх юм бэ гэдгийг Монголбанкны бодлогын хүү хариулсангүй шүү дээ. Харин ч улам хурцатгаад, ажилгүйдэл ядуурлыг нэмэгдүүлээд, эдийн засгийн өсөлтийг дэмжих процесс нь улам багасах тийм шийдвэр болчихлоо. Ерөнхийдөө Монголбанк төгрөгийн ханшийг тогтворжуулах зорилгоор бодлогын хүүгээ өсгөж байгаа бол энэ талаар ярих хэрэгтэй. Гэхдээ шууд зөвшөөрөх боломжгүй. Ер нь бол Монголбанк бодлогын хүүгээ 4.5 нэгжээр өсгөснөөр эдийн засгийн үзүүлэлтүүд яаж өөрчлөгдөх вэ гэдгээ тодорхой хэлэх ёстой байсан. Тухайлбал, мөнгөний ханш, инфляци яаж тогтворжих вэ, эдийн засгийн өсөлт хэд болох юм гээд тоон үзүүлэлтүүдийг гаргаж хэлэх ёстой. Тэгэхгүй агаар руу харж байгаад л

хий буудаж байгаа юм шиг байдал үзүүлээд байна. Ингэж болохгүй. Монголбанк дээр маш нарийн тооцоонууд гарч байх ёстой. Яагаад бодлогын хүүг 10 биш 4.5-аар өсгөчихсэн юм бэ гэдэг тооцоогоо гаргасан байх учиртай. Гэтэл Монголбанкны одоогийн тайлбарыг мэргэжлийн хүмүүс уншихад ямар ч үнэмшилгүй байгаа юм. Бусад орнуудад бодлогын хүүний хүрэх үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлдэг. Гэтэл Монголбанк энэ асуудалд маш ерөнхий утгаар нь хандаж байна. Ажилгүйдэл, инфляци гээд бусад асуудалтай холбогдсон ямар ч тайлбар алга.

Монголбанкны ерөнхийлөгчийн ярилцлагад ч энэ асуудал бүрэн орхигдсон байна. Зүгээр л цээжний бангаар, гурилдсан байдлаар асуудалд хандаж байна уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

Мэдээж хэрэг хайвал гарц байж л таарна. Юуны өмнө Засгийн газар, Монголбанк,

эрдэмтэн судлаачид, эдийн засагчдаа оролцуулаад "Хямралын эсрэг үндэсний зөвлөл"-ийг байгуулах хэрэгтэй. Түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдлаа тал талаас нь ярилцаж, саналаа солилцох нь чухал. Сая эдийн засгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийсэн хүмүүсийн яриа маш хангалттайгүй байна. Эдийн засгийн нөхцөл байдлаа бүрэн хамарч чадаагүй, хагас дутуу ярьж байна. Сангийн сайд нь төсвийн алдагдлаа арай дэндүү хэтрүүлээд мэдэгдэл хийчихлээ. Тэгэхээр МАН-ын Ерөнхий сайд, Сангийн сайд нарын байж байгаагаар хэзээ ч энэ эдийн засгийн хямралыг давж чадахгүй. Энэ хүмүүсийн үгнээс л харагдаж байна. Тэгэхээр яаралтай үндэсний зөвлөлөө байгуулаад, эдийн засагчдыг цуглуулж байгаад асуудлаа хэлэлцээд гарах арга замаа нэн даруй тодорхойлох хэрэгтэй.



Л.Оюун: Ерөнхийдөө эдийн засгийг хумих бодлого барих гэж байна гэдгээ л хэлээд байгаа хэрэг

/МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, эдийн засгийн ухааны доктор, профессор/

-Монгол Улсын эдийн засаг сайжирсан ч юм алга, муудсан ч юм алга. Ер нь бол эдийн засаг гол үзүүлэлтүүдээрээ хямраагүй байгаа шүү дээ. Инфляци, ДНБ-ий өсөлт зэргийг тааж биш тоогоор л ярина. Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлснээр мөнгөний хатуу бодлого барих гэж байгаа явдал. Мөнгөний хатуу бодлого барина гэхээр мөнгөний

арга. Өнөөдөр байгаа банкны системийг илүү тогтвортой болгоход хэрэгтэй нь ойлгомжтой. Гэхдээ, эдийн засгийн бусад хэсэг, салбарууд яах вэ. Бодит эдийн засгаа харахаар цаг хугацааны хувьд энэ шийдвэр оновчтой эсэхэд эргэлзэж байгаа. Эдийн засгийн өсөлт удаширсаар байхад хүүгээ өсгөнө гэдэг бол маш ойлгомжгүй ажил. Ядаж байхад ийм огцом ихээр, гэнэт өөрчилж байгаа нь бас буруу гэж би хувьдаа үзэж байна.

Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлснээр мөнгөний хатуу бодлого барих гэж байгаа явдал. Мөнгөний хатуу бодлого барина гэхээр мөнгөний

нийлүүлэлтийг хумина гэсэн үг. Мөнгөний нийлүүлэлтийг хумихаар ерөнхийдөө эдийн засгийг хумих бодлого барих гэж байна гэсэн үг. Хэрвээ мөнгөө нийлүүлээд байх юм бол худалдан авалт сайжраад, үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалт өсөж, мөнгөний эргэлт сайжирдаг. Тэгэхээр одоо хүүгээ нэмчихээр хумих

бодлого барьж байна гэдгээ хэлээд байгаа хэрэг.

Эдийн засгийн хүндрэлээс гарах хамгийн сайн гарц бол үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлээ л дэмжих хэрэгтэй. Гадны шууд хөрөнгө оруулалт орж ирж болно. Тэгвэл ажлын байр нэмэгдээд, орлого өсөх учиртай. Гэтэл Аж үйлдвэрийн яам алга болсон нь харамсмаар

явдал. Яг үйлдвэрлэгчид рүүгээ хандсан төвлөрсөн бодлого барих газаргүй болчихоор хүндрэлтэй байна байх.



Д.Лхагвасүрэн: Долларын ханшийг бодоод бодлогын хүүгээ өсгөж байгаа нь буруу

/Эдийн засагч/

-Бодлогын хүүг нэмэгдүүлэх замаар долларын ханшийг унагаж, төгрөгийг чангатгаж болно. Энэ бол ойлгомжтой

арга. Өнөөдөр байгаа банкны системийг илүү тогтвортой болгоход хэрэгтэй нь ойлгомжтой. Гэхдээ, эдийн засгийн бусад хэсэг, салбарууд яах вэ. Бодит эдийн засгаа харахаар цаг хугацааны хувьд энэ шийдвэр оновчтой эсэхэд эргэлзэж байгаа. Эдийн засгийн өсөлт удаширсаар байхад хүүгээ өсгөнө гэдэг бол маш ойлгомжгүй ажил. Ядаж байхад ийм огцом ихээр, гэнэт өөрчилж байгаа нь бас буруу гэж би хувьдаа үзэж байна.

Олон улс орон эдийн засгаа сайжрах үед хүүгээ өсгөдөг. Ингэхдээ маш алгуур өсгөдөг. Манайд энэ удаа аль аль нь хэрэгжсэнгүй. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унасан үед уул уурхайн бус салбарыг дэмжих хэрэгтэй. Гэтэл хүү нэмэх нь уул уурхайн бус салбаруудад халтай бодлого. Тэгэхээр эдийн засаг дахь савлагааг улам ихэсгэх эрсдэл бий боллоо. Өнгөрсөн гурван жилд төрөөс барилга, хөдөө аж ахуй руу чиглэсэн зээлийн

бодлогод онцгой анхаарсан нь тохиолдлын хэрэг биш юм. Барилгын салбарт 96 мянган хүн ажилладаг, ХАА-н салбарт манай нийт өрхийн 1/3 нь байдаг. Энэ том салбаруудыг тэтгэх зээлийн бодлогын ирээдүй тодорхойгүй боллоо. Жижиг аж ахуйн нэгжүүд, үйлчилгээний салбар их хүнд нөхцөлд байгаа. Жижиг болон бусдажахуйнхөрөнгөорлуулалт бодлогын хүү өссөнөөс болж огцом буурна. Мөн худалдан авагчид, үйлчлүүлэгчдийн тоо

цөөрнө. Тэр чинээгээрээ ажлын байрны тоо хумигдана. Тиймээс цаашдаа Монгол Улсын гол ажилладаг хүчинг өөртөө агуулдаг эдгээр салбаруудаа тогтвортой дэмжих нь зүйтэй байсан. Монголбанк хүүгээ өсгөсний дараа Засгийн газар цаашид эдгээр салбаруудын хөрөнгө оруулалтыг дэмжих ямар бодлого явуулах нь одоогоор их сонирхол татаж байна.



Ч.Эрдэнэдалай: Монгол Улс одоо маш зоригтой хөдлөх цаг ирээд байна

/Шинжээч/

-Сүүлийн хэдэн жил гадаад хөрөнгө оруулалт тогтмол буурсан. Үүнийг орлож, зээлээр, төсвийн хэмнэлт, мөнгө

хэмнэлт гэсэн гурван зүйлээр аргацааж ирсэн. Үүний эцсийн үр дүн одоо гарч байна. Мэдээж байнга мөнгө хэвлээд, өр тавиад яваад байна гэж байхгүй. Үүний үр дүнд ард иргэд л хамгийн их хохирч байна. Гэхдээ энэ байдлыг засч залруулахаар тодорхой хэмжээний ажил хийж эхлүүлээд байгаа нь сайшаалтай хэрэг. Сүүлийн найман жил гадаад болон дотоод талдаа төгрөгт итгэх

итгэл эрчимтэй суларч байгааг онцлох хэрэгтэй. Мэдээж үүнд нөлөөлөх хүчин зүйл бий. Эдийн засагт нөлөөлөх суурь нөхцөл муу байгаа юм. Тиймээс ч Монголбанк бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан байх. Үүнийг тогтвортой байдлыг хангах гэсэн дунд хугацааны арга хэмжээ юм болов уу гэж харж байна. Ер нь эдийн засгийн хүндрэлийг даван

туулах гарцын тухайд Засгийн газрын гаргаж байгаа зургийг боломжийн үндэслэлтэй төлөвлөгөө гаргаж байна гэж харж байгаа. Нэн түрүүнд төсвөө эрүүлжүүлэхээр ажиллах гэж байна. Энэ бол ерөнхий утгаараа Монгол гэх үрэлгэн айлын санхүүг маш эмх цэгцтэй тодорхой болгох гэж байна. Илүүдэл бүх зардлаа танаад, цаашид бүх нөөц бололцоогоо дайчлах гэж

байгаа нь зөв. Монгол Улс одоо маш зоригтой хөдлөх цаг ирээд байна гэж харж байна даа. Эдийн засгийг тогтворжуулах маш нарийн төлөвлөгөө хэрэгтэй. Хамгийн гол нь төр, засаг нь чадамжаа сайжруулах зайлшгүй шаардлагатай. Үүнийг хэрэгжүүлж чадвал эдийн засаг болон ДНБ өснө гэж харж байна.



Р.Амаржаргал: Ирэх онд эдийн засгийн нөхцөл байдал дээрдэх учиртай

/УИХ-ын гишүүн асан/

-Монголбанкбодлогынхүүгээ 15 хувь болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь зөв,

буруу гээд шуудхан хэлэхэд одоохондоо хэцүү байна. Тодорхой загвар боловсруулж, янз бүрийн хувилбараар үзэж байж шийдвэр гаргасан байлгүй. Сүүлийн үед төгрөгийн ам.доллартай харьцах хэлбэлзэл дээшилж, доошилж байна. Үүнтэй холбоотойгоор хүлээлт үүсээд байна гэж ойлгож байгаа. Монголбанк, Сангийн яам хоёр аль нь ч эдийн засгийн

хүлээлтийг залж чиглүүлэхдээ их муу. Ханшийн хэлбэлзэл хүчтэй байгаад сөрөг гэж хэлж болохоор үр дагавартай болсноос гадна улс төрийн учир шалтгаан ч байгаа байх шиг. Өөрөөр хэлбэл, доллар төгрөгийн ханшийн хэлбэлзэл ямар байхаас шалтгаалж бодлогын хүүгээ нэмлээ гэж харж байна. Ирэх онд эдийн засгийн нөхцөл байдал дээрдэх

учиртай гэсэн хүлээлт байгаа. Хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн индексийг харж байхад тод харагдахгүй байгаа боловч дээшлэх хандлага ажиглагдсан байна. Би энийг сайн эхлэл болов уу гэж харж, горьдож байгаа. Гэхдээ хадгалж чадах эсэхийг мэдэхгүй. Сангийн яамнаас оруулж ирэх бодлого, үйл ажиллагаа ихээхэн нөлөөлөх байх. Тун

удахгүй төсвийн тодотгол орж ирнэ. Төсвийн тодотгол жинтэй нөлөө үзүүлнэ. Мөн Монголбанк, Сангийн яам хоёр нэг долгион дээр хамтраад ажиллаж чадах нь уу, эсвэл тус тусдаа нэгнийгээ чирээд явчих нь уу гэдэг нь сонин үзэгдэл. Энэ бүгдийг тооцоолох ёстой байх.

ДЭЛХИЙ



...Трампын хувьд Нью-Йоркт өөрийн эзэмшлийн Трамп таурт саяхан латин америк гаралтай дэмжигчидтэйгээ уулзалт хийсэн байдаг. Тэгвэл уулзалтад оролцсон дэмжигчид нь Испанийн "Univision" гэх телевизэд Трамп хууль бус хэдэн зуун мянган цагаачдад хотын иргэдийн адил эрхийг олгох талаар ярьсан тухай мэдээлжээ. Энгийн иргэдийн яриаг мөн уулзалтад оролцсон Техас мужийн дүрвэгсдийн асуудлаар мэргэшсэн нэгэн өмгөөлөгч ч баталсан байна...

ДОНАЛД ТРАМП БОДЛОГОО ШИНЭЧИЛЛЭЭ

Б.ДАВААХУЙ

АНУ-ын 43 дахь Ерөнхийлөгч Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан ирэх арваннэгдүгээр сард Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдах билээ. Сонгуульд улстөрийн туршлагагүй ч, бизнесийн амжилтаараа олон хүний итгэлийг хүлээн үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтонтой өрсөлдөж буй. Сонгууль болоход хэдхэн сарын хугацаа үлдсэн энэ

үед Ардчилсан нам болон Бүгд найрамдах намын нэр дэвшигчдийн хоорондын өрсөлдөөн улам ширүүсч эхлээд байна. Гадаадын зарим ажиглагчид ирэх сонгуульд хэрэв Хиллари Клинтон ялбал, одоогийн Ерөнхийлөгч Барак Обамагийн улстөрийн бодлого үргэлжилнэ гэж үздэг. Харин Доналд Трамп сонгогдвол хэзээний дайч бодлогыг баримталдаг Бүгд Найрамдах намын хатуу бодлого дахин үргэлжлэх төлөвтэй байгааг онцолдог. Үүнийг батлах мэт Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэдгээр зарласан мөчөөс Доналд Трамп

мусальман шашинтнууд цагаачдын эсрэг хатуу бодлого баримтална гэдгээр зарлаж, мексикчүүд болон мусальман шашинтнуудын эгдүүдийг төрүүлээд байв. Тэгвэл сонгууль дөхсөн энэ үед шоу бизнесмэн эр өөрийн улстөрийн бодлогоо шинэчлэлт хийж, зөөлрүүлэх болсон байна. Тодруулбал, АНУ-ын дараагийн Ерөнхийлөгчөөр хэрэв сонгогдвол Доналд Трамп улс оронд нь хууль бусаар оршин сууж буй нийт 11 сая цагаачийг хүчээр хөөж гаргана гэсэн бодлоо өөрчилсөн аж. Дэмжигчдийнх нь хувь өдөр ирэх бүр унасан үзүүлэлттэй байгаа тэрбээр саяхан

сонгуулийн кампанитынхаа менежерыг сольсон. Түүнд эдүгээ Келлианне Конвэй гэгч эмэгтэй зөвлөх болсон бөгөөд үүний дараагаас дэмжигчдийнхээ тоог өсгөх зорилгоор Доналд бодлогоо өөрчилсөн хэмээн зарим эх сурвалж мэдээлж байна. Трампын хувьд Нью-Йоркт өөрийн эзэмшлийн Трамп таурт саяхан латин америк гаралтай дэмжигчидтэйгээ уулзалт хийсэн байдаг. Тэгвэл уулзалтад оролцсон дэмжигчид нь Испанийн "Univision" гэх телевизэд Трамп хууль бус хэдэн зуун мянган цагаачдад хотын иргэдийн адил эрхийг

олгох талаар ярьсан тухай мэдээлжээ. Энгийн иргэдийн яриаг мөн уулзалтад оролцсон Техас мужийн дүрвэгсдийн асуудлаар мэргэшсэн нэгэн өмгөөлөгч ч баталсан байна. Тэдний хэлснээр Трамп "Хууль бусаар оршин сууж буй 11 сая цагаачид АНУ-д том асуудал үүсгэж байгаа нь үнэн. Гэхдээ тэднийг албадан нутаг буцаах нь хүмүүнлэг ёсонд харшилна" гэж уулзалтын хариу онцолсон гэнэ. Түүний сонгуулийн сурталчилгааны менежер Келлианне Конвэй ч "Си Эн Эн" телевизэд өгсөн ярилцлагадаа Д.Трамп тун удахгүй хууль бус цагаачдад

чиглэсэн бодлогынхоо талаар дэлгэрэнгүй тайлбар хийнэ гэж ярьсан аж. Гэхдээ "Албадан нутаг буцаана" гэсэн заалт орсон эсэх талаар асуухад "Одоогоор хараахан шийдээгүй" гэх тайлбарыг өгсөн байх юм. Ямартай ч, АНУ-ын Ерөнхийлөгч болбол Мексикийн хилд аварга том хана босгоно, хууд бус цагаачдыг хүчээр нутаг буцаана, мусальман шашинтнуудыг АНУ-ын хил нэвтрүүлэхгүй гэх мэтээр хачирхалтай мэдэгдлийг хийж байсан үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан улстөрийн бодлогоо шинэчлэлт хийж, зөөлрүүлж эхэлсэн байна.

Японы Элчин сайд Иранд саатуулагджээ

Иранд энэ оны дөрөвдүгээр сард оройн зоог барих ёслолын ажиллагаанд оролцсоныхоо төлөө Япон улсаас тус улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин Сайд тус улсын аюулгүйн албаныханд саатуулагдсан тухай "Эн Эйч Кэй" мэдээллээ. Улмаар Японы тал олон улсын конвенц зөрчигдөж, дипломатуудынх нь эрх зөрчигдөж байгааг эсэргүүцэн Ираны Гадаад хэргийн яаманд гомдол гаргасан байна. Иран дахь Японы Элчин сайдын яамны албаны хүний хэлж буйгаар Кобаяши Хироюсу сайд танилхнаа зохион байгуулсан оройн зоогт эхнэрийнхээ хамт оролцсон аж. Гэвч тухайн газар нь аюулгүйн албаныхан гэнэт шалгалт хийж, Японы дипломатчдыг түр хугацаанд саатуулжээ.

Зукерберг амлалтаа биелүүлэв

Фэйсбүүк нийгмийн сүлжээний сайтын үүсгэн байгуулагч Марк Зукерберг өнгөрсөн жил анхны хүүхдээ өлгийдөн авч, аав болсон. Тэрбумтнууд дундаа хамгийн өгөөмөр гэдгээрээ алдартай тэрбээр энэ баярт үйл явдлыг тохиолдуулан, мөн дэлхийн бүх хүүхдийг илүү сайн сайхан дэлхий ертөнцөд амьдруулахын тулд нийт орлогынхоо 99 хувийг буяны үйлст зориулна гэдгээр албан ёсоор мэдэгдэж байсан билээ. Тэгвэл Зукерберг амлалтаа биелүүлж, их хэмжээний мөнгийг буяны үйлст зориулж

эхэлжээ. Тэрбээр өнгөрсөн долоо хоногт хувьцаагаа бэлэн мөнгө болгож эхэлсэн байх юм. Лхагва болон пүрвэг гарагт гэхэд нийтдээ 767905 хувьцааг худалдаж, 95 сая ам.долларыг босгожээ. Тэрбумтан эр анх удаагаа буяны үйл ажиллагаанд зориулан хувьцаагаа худалдсан нь энэ. Ирэх гурван жилд жил бүр нэг тэрбум ам.долларын үнэ бүхий хувьцааг худалдан буяны үйлст зарцуулахад хөрөнгө нь хангалттай хүрнэ хэмээн Зукерберг төлөвлөж буй аж.

АНУ, БНСУ-ын хамтарсан цэргийн сургуулилт эхэллээ

АНУ, БНСУ-ын хамтарсан цэргийн сургуулилт өчигдрөөс албан ёсоор эхэллээ. Тус хоёр улсын цэргийн сургуулийг БНАСАУ-ын зүгээс удаа дараа эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн ч, тэдний сүрдүүлийг эс тоон ийнхүү эхэлсэн байна. Харин Пхеньян сургуулилттай холбоотойгоор харуу цохилт үзүүлнэ гэдгээр анхаарууллаа. Жил бүр хоёр долоо хоногийн хугацаатайгаар АНУ, БНСУ-ын цэргийнхний хамтарсан сургуулилт болдог бөгөөд энэ удаа Сөүлийн талаас 50 мянга орчим,

АНУ-аас 25 мянган цэрэг оролцож буй ажээ. Жил бүр тус цэргийн сургуулилттай зэрэгцэн Өмнөд болон Хойд Солонгосын зөрчил хурцагдах ч, энэ жил БНАСАУ-ын өндөр албан тушаалтан Сөүлд орогносон тул сүрдүүлэг биеллээ олж болзошгүй зарим эх сурвалж анхааруулж байна. Орон нутгийн зарим сайтуудын мэдээлснээр Пхеньян цөмийн зэвсэг эсвэл баллистик пуужингийн туршилт хийж болзошгүй гэнэ. Цэргийн сургуулилт ирэх сарын 2-ныг хүртэл үргэлжилнэ.

Сингапурын Ерөнхий сайд илтгэлийнхээ үеэр ухаан алджээ

Сингапурын Ерөнхий сайд Ли Хсен Лун орон нутгийн телевизын шууд нэвтрүүлгийн үеэр ухаан алдан унажээ. Эдүгээ 64 настай улстөрч тэрбээр телевизийн шууд нэвтрүүлгийн үеэр илтгэл тавьж байхдаа ухаан алдан унаж, нэг хэсэгтээ эмх замбараагүй байдал үүсгээд амжсан байна. Тэрбээр ухаан алдаж унасны улмаас илтгэлээ түрхугацаанд завсарласан ч, хэсэг хугацааны дараа дахин үргэлжлүүлж дуусгасан тухай олон улсын хэвлэлүүд онцоллоо. Түүний тавьсан илтгэл наймдугаар сарын 9-ний өдөр тохиосон улс тунхагласны 51 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан байна. Гэвч Ерөнхий сайд илтгэлээ тавьж эхэлснээс хойш хоёр цаг орчим хугацааны дараа гэнэт зогтосон унаан алдан унажээ. Харин хэсэг хугацааныхаа

дараа сэргэж, хүнээр түшүүлэн цаг 20 минут түр амсхийгээд дахин илтгэлээ үргэлжлүүлэн өндөрлүүлсэн байна. Энэ явдлын үеэр санаа зовнисон ард иргэд нь сайдаа дахин гарч ирэхийг тэвчээртэйгээр хүлээж, социал медиа ч Ерөнхий сайдаа санаа тавьсан сэтгэгдэл постуудаар дүүрсэн аж. Харин Ли Хсен Лун "Намайг тэвчээртэйгээр хүлээж байсанд баярлалаа. Та бүхнийгээ сандаргачихлаа" хэмээн ард иргэдээ тайвшруулсан байна. Ямартай ч, түүний ойрын эх сурвалжууд түүнийг сүүлийн үер ядарч, шингэн алдсаны улмаас ухаан алдсан гэж тайлбарлаж байгаа юм. Анх 2004 онд Сингапурын Ерөнхий сайдаар томилогдсон Ли Сингапурын эцэг гэгддэг Ли Кван Югийн хүү билээ.

РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ ҮЙЛДВЭРЛЭЛ-УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

Элсэлтийн бүртгэл:
2016 оны 8 -р сарын 10-наас 26-ныг хүртэл (өдөр бүр 09:00-18:00 цаг)

Дараах мэргэжлээр элсэлт авч байна

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

СУРГУУЛИЙН ДАВУУ ТАЛ:

- Магадлан итгэмжлэгдсэн сургалтын төлбөргүй (мэргэших зардлаас бусад) төрийн өмчийн сургууль.
- Техникийн боловсролтой төгсөгчид Их, дээд сургуулийн 2-3 курсаас эхлэн суралцах боломжтой.
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар мэргэжлийн иж бүрэн лаборатори, сургалтын газраар бүрэн хангагдсан.
- Сургууль нь 19000 гаруй номын фонд, 50 суудалтай уншлагын танхим бүхий номын сантай.
- Орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжтэй, дадлагын газарт үйлдвэрийн дадлага хийх боломжтой.
- Суралцагчид өөрийн сонирхсон чиглэлээр дугуйлан сэцэнд үнэ төлбөргүй хамрагдан суралцах боломжтой.
- Оюутан солилцоогоор Солонгос, Энэтхэг болон бусад орнуудын ижил төрлийн сургуулиудтай танилцаж , аялах боломжтой.
- Суралцагч өөрийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргах, бүтээлээ зах зээлд борлуулах боломжтой.

ОЮУТАН СУРАГЧДАД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ

- Хөдөө орон нутгийн суралцагсад дотуур байраар үнэ төлбөргүй хангагдана.
- Амжилттай суралцагчдын мэргэшүүлэх зардлыг тодорхой хувиар хөнгөлнө.
- Суралцагчид сар бүр 70000 төгрөгийн тэтгэлэг авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй, хагас болон бүтэн өнчин суралцагчдын мэргэшүүлэх зардлыг 1 удаа 50-100% хөнгөлнө.
- Нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих эрх эдлэнэ.
- Мэргэжлийн чиглэлээр олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцох боломжоор хангана.

№	Мэргэжл	Элсэлтийн боловсролын түвшин	Суралцах хугацаа	Мэргэжил олгох боловсролын баримт бичиг
1	Үйлдвэрийн график дизайн	Бүрэн дунд 12-р анги төгссөн	3 жил	Төвнийн боловсролын диплом
2	Дизайнч хушцааны			
3	Авто машины механик			
4	Чимэглэх урлаг	Бүрэн дунд 12-р анги төгссөн	1.5 жил	Төвнийн боловсролын диплом
5	Мехатроник			
6	Нягтлан бодогч, төлбөр тооцоо цалин хөлсний			
7	Технолологч, ус засах урлагийн			
8	Технолологч, гоо сайоны урлагийн			
9	Вэб мультимедиа			
10	Цэцгийн техник			
11	Техник холболт сулжаа	Сүүр, Бүрэн дунд Боловсрол	2.5 жил	Мэргэжлийн болон бүрэн дунд боловсролын үнэмлэх
12	Үсний			
13	Гоо засалч			
14	Авто машины засварчин			
15	Арсавар гар урлагийн зүйл урлагч			
16	Гар урлагийн зүйл урлагч			
17	Үнэгт адалгийн дорхон			
18	Зураач, чимэглэгч			
19	Оюул бүтээгдэхүүний өдсөгчин			
20	Авто машины засварчин			
21	Цэцэрлэгч, цэцэрлэгт хүрээлэнгийн			
22	Савуу буталт тоосгооны туслах ажилтан			
23	Хөвсгөл үйлдвэрийн хөвсгөлч			

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10-р хороо
Утас/Факс: 99658848, 96563033, 89063459

Вэб хуудас: www.pas.mn
И-мэйл: gandhi_school@past.edu.mn

ШУУРХАЙ МЭДЭЭ

35 настай эрэгтэйг дайрч, хөнөөжээ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газарт өнгөрсөн амралтын өдрүүдэд нийт 438 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 314 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 18 бүртгэгдэж, нэг хүний амь нас хохирч, 24 хүн хүнд, хөнгөн гэмтсэн. Харин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд холбогдсон жолооч нэг, явган зорчигч хоёр, сургуулийн өмнөх насны гурван, сургуулийн насны нэг хүүхэд өртсөн байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 127 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэрэгээ урьдчилан сэргийлж ажиллажээ. Тухайлбал, Сонгинохайрхайн дүүргийн нутаг Баянхошууны замд “Жанцан” дэлгүүрийн уулзварт амины Ptius маркийн автомашины жолооч Л нь явган зорчигч 35 настай, эрэгтэй М-г мөргөж, хохирогч ГССҮТ-д хүргэгдэн эмчлэгдэж байгаад нас барсан байна. Түүнчлэн Баянгол дүүргийн нутаг Баруун-4 замын уулзварт марк, улсын дугаар тодорхойгүй автомашины жолооч нь явган зорчигч 45 настай, эмэгтэй Н-г мөргөж гэмтээгээд хэргийн газрыг орхиж явсан хэргийг шалгаж байна. Тиймээс нийт жолооч нарыг замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжтой байхыг ЗЦП-аас анхааруулж байна.

Хээрийн түймэр гарчээ

Намрын улирал эхэлж, өвс ногоо шарлаж эхэлсэн. Үүнтэй зэрэгцээд түймэр гарах болсон байна. Тухайлбал, энэ сарын 18-нд Дорнод аймгийн Матад сумын Түмэнхаан багийн “Уулын-Өвөр” гэдэг газар хээрийн түймэр гарсан байна. Түймрийн дуудлагыг наймдугаар сарын 18-ны оройн 17:38 цагт хүлээн авчээ. Дуудлагын дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын

12 албан хаагч, нэг автомашин, орон нутгаас 27 хүн, дөрвөн автомашин, нийт 39 хүн, таван техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, түймрийг бүрэн унтраасан байна. тиймээс малчид, иргэдийг аялал зугаалганд явах үедээ асаасан галаа гүйцэт унтраах, тамхины цогтой иш хаяхгүй байхыг Онцгой байдлын ерөнхий газраас анхаарууллаа.

Зорилтот бүлгийн иргэдийг В,С вирусийн вакцинжуулалтад хамруулна

Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв, “JCI” Лидертөрийн бус байгууллагатай хамтран элэгний В,С вирус болон хавсарсан хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх ажлыг эхлүүлээд байгаа. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс элэгний В, С вирусийн шинжилгээ авч, урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулах ажлыг эхлүүлсэн байна. Вакцинжуулалт өчигдрөөс эхэлж, наймдугаар сарын 25-ныг дуустал буюу энэ

пүрэв гараг хүртэл үргэлжилнэ. Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн хоёрдугаар байранд зохион байгуулж буй вакцины аянд идэвхтэй оролцохыг уриалж байгаа ажээ. Нийгмийн зорилгод бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэхээр энэхүү хүмүүнлэгийн ажлыг эхлүүлээд байгаа албаныхан онцолж байна.

Д.ЭНХЦЭЦЭГ: ӨДӨРТ 500 ИРГЭН ГАДААД ПАСПОРТ ЗАХИАЛЖ БАЙНА

Н.БАТЗАЯА

Оюутан, сурагчдын хичээл эхлэхтэй зэрэгцээд гадаад паспортын эрэлт, хэрэгцээ ихэсч, гадаад паспорт захиалах хүсэлтэй иргэдэд олширдог. Тиймээс УБЕГ-ын гадаад паспортын газрын дарга Д.Энхцэцэгээс зарим зүйлийг тодрууллаа.

-Гадаад паспортын бэлдэц дууссан гэсэн мэдээлэл байсан. Одоо хэвийн олгогдож эхэлсэн үү?

-Гадаад паспортын бэлдэц дууссан гэсэн зүйл байхгүй. Манай гадаад паспортын газарт өдөрт 500 хүн шинээр паспорт гаргуулахаар ханддаг. Бид ирсэн хүн болгонд үйлчилж, захиалга өгсөн иргэдийн паспортыг хугацаанд нь олгож байгаа. Өөрөөр хэлбэл, өдөр бүр шинээр 500 паспортын захиалга авч, олгож байна гэсэн үг. Тэгэхээр гадаад паспортын захиалга хэвийн явагдаж байна.

-Жил бүрийн өдийд гадаад паспортын захиалга ихэсдэг шүү дээ. Нэмэлт цонх гаргаж ажиллаж байгаа юу?

-Энэ жил иргэдийн гадаад паспорт авах захиалга харьцангуй ихэслээ. Өмнөх

онуудтай харьцуулахад 30 хувиар өссөн байна. Тухайлбал, 2014 онд 13.200 гаруй иргэн, 2015 онд 190.100 иргэн гадаад паспорт шинээр захиалсан байдаг. Харин өнгөрсөн долдугаар сарын байдлаар 120.000 иргэн гадаад паспорт захиалж авсан. Ер нь долдугаар сараас хойш өдөрт 1500 гаруй иргэн хүлээж авч байсан. Ачаалал ихтэй үед бусад нэгжүүдээсээ улсын бүртгэгчдийг нэмэлтээр ажиллууллаа. Учир нь хүмүүс амралтаа тааруулаад аялал зугаалгаар явдаг учраас ийм зохицуулалт хийсэн. Гадаад паспорт захиалахаас гадна сунгалт хийх үйлчилгээ бий. Энгийн үед хоногт 200 иргэн сунгалтын үйлчилгээ авдаг байсан бол ачаалалтай үед 600 болж өссөн. Энэ мэтчилэн зохицуулалтын ажлыг хийлээ. одоо ачаалал харьцангуй багассан. Гэсэн хэдий ч гадаад паспорт захиалах иргэдийн дугаарлалт дуусаагүй байна.

-Сүүлийн үед манай улсын иргэд гадаад руу аялахдаа хүүхдээ авч явдаг болсон шүү дээ. Сургууль, цэцэрлэг орох дөхөөд ирэхээр хүүхдийнхээ хувцсыг бэлдэж Эрээн гарах хүн олон болдог. Хэрвээ хүүхдээ дагуулж гарах бол

ямар материал бүрдүүлэх вэ?

-Тийм. Оюутан, сурагчдын хичээл эхлэхтэй зэрэгцээд гадаадаас хувцас, хичээлийн хэрэгслээ бэлдэх тохиолдол ихэссэн. Гадаад паспорт захиалахдаа 16-аас дээш насны иргэн өөрийн биеэр ирэх ёстой. Ингэхдээ иргэний үнэмлэх, стандартын шаардлага хангасан гурван хувь цээж зураг авч ирэхэд болно. Мөн захиалгын мөнгийг банкинд тушаасан байх шаардлагатай. Харин гадаад руу 16-аас доош насны хүүхэд авч явахаар болбол тухайн хүүхдийн эцэг, эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч нь өөрийн биеэр ирэх ёстой байдаг. Бүрдүүлэх бичиг баримтын хувьд мөн адил. Эцэг, эхийн иргэний үнэмлэх, хүүхдийн төрсний гэрчилгээ, гурван хувь цээж зураг, мөнгөө тушаасан байх хэрэгтэй. Эдгээр зүйлийг бүрдүүлэхэд болно.

-Яаралтай гадаад паспорт захиалгын үйлчилгээг зогсоосон гэсэн?

-Иргэдийн амралт зугаалгын цаг болсон учраас гадаад улсыг зорих иргэд их байна. Үүний улмаас гадаад паспортын газрын ачаалал ихэссэн. Тиймээс бид яаралтай үйлчилгээг түр хугацаагаар хойшлуулсан байгаа. Тодруулбал, ажлын

...Сунгалтын үйлчилгээний нэгдсэн төвд хийгдэж байгаа. Мөн 100 айл дахь салбарт гадаад паспортын сунгалт хийгдэж байна. Сунгалт хийлгэх бол иргэний үнэмлэх хэрэг болно. мөн гадаад паспорт авах мэдүүлэг бөглөх ёстой...

багтаж авч байна.

-Гадаад паспортыг ямар тохиолдолд хүчингүй болгодог юм бэ?

-Гадаад паспортыг хүчингүй болгох хэд хэдэн тохиолдол бий. Тухайлбал, эзэмших, ашиглах хугацаа дууссан паспортад улсын хил нэвтрэх тухай тэмдэглэл хийх зайгүй болж хуудас дууссан, тухайн хүний зураг танигдахааргүй өөрчлөгдсөн бол хүчингүй болно. Мөн охид, бүсгүйчүүд гоо сайхны мэс ажилбар хийлгэдэг. Энэ тохиолдолд мөн хүчингүй болгоно. Түүнчлэн эрх бүхий байгууллагын шийдвэрээр овог, эцэг, эхийн нэр, регистрийн дугаар өөрчилсөн, гадаад паспорт болон түүнтэй адилтгах баримт бичгийг бусдад шилжүүлж хуурамчаар ашигласан, гэмтээсэн, үрэгдүүлсэн, хууль бусаар засвар хийсэн бол хүчингүй болгох заалт бий.

-Сунгалт хийлгэх гэж буй иргэд хаана хандах вэ?

-Сунгалтын үйлчилгээний нэгдсэн төвд хийгдэж байгаа. Мөн 100 айл дахь салбарт гадаад паспортын сунгалт хийгдэж байна. Сунгалт хийлгэх бол иргэний үнэмлэх хэрэг болно. мөн гадаад паспорт авах мэдүүлэг бөглөх ёстой.

Монгол-Солонгос сэтгүүлчдийн хоорондын харилцаа улам өргөжинө

Ц.СОЛОНГО

Монгол Улс-БНСУ-ын сэтгүүлчдийн холбоотой өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хамтран ажилласан хамтын ажиллагаагаа танилцуулж, хоёр талын уулзалт зохион байгууллаа. Энэ хугацаанд удаа дараа төлөөлөгч солилцож, ойр дотно түнш болон Монгол-Солонгосын хоорондын харилцаа улам хөгжиж байгаа гэдгийг төлөөлөгчид илэрхийлж байлаа. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хоорондын харилцааг хөгжүүлэх, тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэх ажил одоогоор судалгааны төвшинд явагдаж байгаа юм байна. Мөн Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээр дамжуулаад харилцаа холбоо тогтоож байгаа байгууллагууд цөөнгүй байдаг. Тэгвэл тухайн байгууллагууд хоорондоо шууд харилцах эсвэл тодорхой сэдвийн

дор солилцооны сэтгүүлчдийг хоёр улсад сурвалжлага хийлгэх ажил хэрэгжээд байгаа юм байна. Солонгос улсаас өнөөдрийн уулзалтад телевиз болон сонингийн төлөөлөл болж салбар бүрээс нэг хүн ирснээс Солонгосын томоохон телевиз болох NBS, KBS, SBS телевизүүдийн төлөөлөл болсон сэтгүүлчид ирсэн байна.

Энэ удаагийн уулзалтаар Солонгосын сэтгүүлчдэд Монгол Улсыг таниулах мөн Монгол-Солонгосын сэтгүүлчид хоорондоо танилцан найзлаж нөхөрлөх боломжтой болж байгаагаараа давуу талтай уулзалт боллоо. Цаашдаа Монгол Улсын түүх соёлыг дэлхийд танин мэдүүлэх тал дээр илүү ажиллахыг зорьж буйгаа Монголын талаас илэрхийлсэн билээ. Мөн хоёр орны сэтгүүлчдийн чадавхи, солилцооны ажлыг илүү хөгжүүлнэ гэдгээ ярилцсан юм.

PHOTO NEWS



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн бие бүрэлдэхүүн Тэс нефролизт шатаахуун түгээх станц дээр гал унтраах тактикийн сургууль очигдөр зохион байгууллаа. Тус сургуульд Чингэлтэй дүүргийн хэлтэстэй 17 шатаахуун түгээх станцын 45 ажилтан, албан хаагчид оролцов. Сургалтад оролцогчид галшигаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимын сургалтад хамрагдаж, гал унтраах дадлага сургууль хийсэн юм.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Хулгайчаас болгоомжил

Өнгөрсөн амралтын өдрүүдэд Улаанбаатар хотын цагдаагийн газарт хулгай дээрмийн шинжтэй нийт 70 хэрэг бүртгэгджээ. Тодруулбал, Баянзүрх дүүргийн “Хавдар судлалын үндэсний төвийн автобусны буудлын орчим энэ сарын 19-ний 12:00 цагийн үед, 25 настай эрэгтэй Г нь 25 настай эмэгтэй А-ын цүнхнээс хэтэвчтэй бичиг баримт, 100 мянган төгрөг хулгайлж байсныг цагдаагийн алба хаагчид үйлдэл дээр нь илрүүлсэн байна. Мөн тус дүүргийн “Моносын нийтийн байрны ..

тоот өрөөнөөс гурван гар утас алдагдсан байна” гэсэн мэдээлэл цагдаагийн газарт ирсэн аж. Дуудлагын дагуу шалгахад Д 25 настай эрэгтэй М өрөөнийхөө хаалга, цонхыг онгорхой унтаж байхад “Samsung Note-2”, “LG-200”, “Samsung S-5” гар утасыг нь 30 настай эрэгтэй бусадтай бүлэглэн хулгайлсныг шуурхай эрэн сурвалжилж илрүүлсэн байна. Тиймээс хулгайч нараас өөрийн эд зүйлийг хамгаалж, анхаарал болгоомжтой байхыг Цагдаагийн газраас сэрэмжлүүлжээ.

Цэцэрлэгийн бүртгэл эхлэв

Улсын болон хувийн цэцэрлэгүүдийн бүртгэл өчигдөр эхэллээ. Бүртгэл энэ сарын 22-26-ныг хүртэл буюу тав хоног үргэлжилнэ. Улсын цэцэрлэгүүд хоёр настайгаас дээш настай хүүхдүүдийг бүртгэж авах аж. Харин 2015 онд төрсөн хүүхдийг бүртгэж авахгүй юм байна. Өнгөрсөн жилийн хичээлийн шинэ жилтэй харьцуулахад, 2016-2017 оны хичээлийн жилд

16 мянган хүүхдээр цэцэрлэгийн элсэлтийн тоог нэмэгдүүлэхээр зохион байгуулж байгаа аж. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд 60 гаруй цэцэрлэг шинээр барьж, нийт 6000 орчим хүүхдийг хүлээн авах боломжтой болсон байна. Дээр нь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгүүдийн орон тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх, мөн хувийн компани, аж ахуйн нэгжүүд

дэргэдээ цэцэрлэг байгуулж ажиллах нөхцөлөөр хангаж, тусгай зөвшөөрөл олгосноор 6000 хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломжтой гэж үзжээ. Мөн Хүүхэд харах үйлчилгээний төвөөр дамжиж 4000 хүүхдийг цэцэрлэгт хамруулснаар ирэх хичээлийн жилд цэцэрлэгийн хүртээмжийг 16 мянгаар нэмэгдүүлэх боломжтой юм байна.

ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

“Али хаус констракшн” ХХК-ийн гэрчилгээний дугаар 0000094144, улсын бүртгэлийн 9011502058 дугаартай бүртгэлийн гэрчилгээ, БУ162255/14 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

ЭЛСЭЛТИЙН ЗАР

“Зохиомж” дээд сургуулийн дэргэдэх “ТОП” Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь IX анги төгсөгчдөөс дараах мэргэжлээр элсэлт авч байна.

- Үүнд:
- Хүний нөөцийн ажилтан 2.5 жил
 - Дууны оператор 2.5 жил
 - Дүрс бичлэгийн оператор 2.5 жил
 - Хэвлэлийн дизайн 2.5 жил
 - Нүүр хувиргалт /make up/ 2.5 жил

Элсэгчид суралцах хугацаандаа сар бүр 70.000 төгрөгийн тэтгэлэг авч, бүрэн дунд боловсролын үнэмлэх, мэргэжлийн дипломтой төгсөнө. Дадлагыг кино, телевиз, театр урлагийн салбарт хийлгэнэ. Төгсөгчдийг ажлын байраар 100 хувь хангана.

Бүртгэл: “Зохиомж” дээд сургууль
Утас: 80810890, 99036396

“Зохиолж” дээд сургууль нь дараах мэргэжлээр өдөр 4 жил, орой, эчнээ 4 жил, 2.5 жил, хөрвөх 1.5 жилийн бакалавр, Бизнес удирдлага, Урлаг судлал, Сэтгүүл зүйн тагистрын ангид элсэлт авч байна.

- Олон улсын сэтгүүлч, орчуулагч
- Телевизийн сэтгүүлч, зураглаач
- Телевизийн сэтгүүлч, найруулагч
- Кино, драмын жүжигчин
- Кино, телевизийн найруулагч
- Бага ангийн багш
- Сургуулийн өмнөх боловсролын багш
- Эрх зүй
- Гааль, гадаад худалдаа

Бүртгэл: “Зохиомж” дээд сургууль Утас: 91111187, 99608440

ЗАВСАРЛАГА

АМЖИЛТЫН ЭЗЭД



Н.ПУНЦАГБОЛД

Хятад улсад болсон "China open" таеквондогийн Олон улсын тэмцээнд оролцож, хоёр алтан медаль хүртээд ирсэн "Ирээдүй" цогцолбор сургуулийн "Чоно" клубын тамирчин О.Амин-Эрдэнэтэй ярилцлаа. Мөн тэрбээр сүүдэр тулааны төрөлд багараа хүрэл медаль хүртсэн билээ.



О.АМИН-ЭРДЭНЭ:

Миний мөрөөгөл дэлхийн аварга болох

-Таеквондо гэдэг тулааны спорт. Эмэгтэй хүүхэд хичээллэхэд хэцүү биш үү. Яагаад энэ спортыг сонгон хичээллэж эхлэв?

-Би хоёрдугаар ангиасаа авахуулаад энэ спортоор хичээллэж эхэлсэн. Одоо

...Улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж байсан. Мөн Орост болсон "Байгаль цом" тэмцээнд оролцож, түрүүлж байлаа. Сая оролцсон Хятадын нээлттэй тэмцээн бол Олон улсын хэмжээний хоёр дахь тэмцээн байсан...

би зургадугаар ангид орно. Сүүлийн гурван жил гаруй таеквондогийн спортоор хичээллэж байна. Энэ спортын тамирчдын бие биеэ хүндэлж байгаа байдал, хүндлэл нь таалагдаад хичээллэсэн дээ. Манай сургууль дээр таеквондогийн "Чоно" клуб байдаг юм. Би энэ спортоор хичээллэж

байгаа хүүхдүүдийг хараад, өөрөө сонирхоод орсон. Бас аав маань ч их дэмжсэн болохоор өнөөдрийг хүртэл хичээллээд явж байна.

-Сая Хятадад "China open" олон улсын нээлттэй тэмцээн болсон. Энэ тэмцээнээс хоёр алтан медаль аваад ирсэн байна. Ямар хоёр төрлөөр алтан медаль авсан бэ?

-Тулааны төрөлд миний жинд ердөө л хоёр тамирчин байсан юм. Тийм болохоор шууд алтан медалийн төлөө Хятадын тамирчинтай тулалдсан. Тулааны төгсгөлд шүүгчдийн 100 хувийн саналар өрсөлдөгчөө ялж, алтан медаль авсан. Харин сүүдэр тулаан буюу тулийн төрөлд нийтдээ 32 хүүхэд өрсөлдсөн. Хятад, Узбекистаны шилдэг тамирчид оролцсон ч би маш сайн хичээж, алтан медаль авч чадсан.

-Сүүдэр тулааны техникийг яаж үзүүлэх ёстой байдаг юм бэ. 31 тамирчнаас хамгийн сайн нь байж алтан медаль хүртсэн гэхээр техникүүдээ маш сайн үзүүлсэн байх нь?

-Багшийнхаа зааснаар маш сайн үзүүлэхийг хичээсэн. Тиймдээ ч алтан медаль авсан байх. Тэнд байхад Хятадын дасгалжуулагч багш нар намайг их тоож байгаа талаар дасгалжуулагч багш нар маань ярьж байсан. Тэгэхээр би бусад тамирчдаас ямар ч байсан илүү амжилттай үзүүлж чадаж гэж бодож байлаа. Сүүдэр тулааныг хийхэд их олон зүйлийг нарийн биелүүлэх хэрэгтэй

болдог. Амьсгал, тэнцвэр, хэмжээ гээд бүх зүйл тэгш байж гэмээнэ уран харагддаг. Гар ямар хэмжээнд байх ёстой, яг л тэр хэмжээндээ байх хэрэгтэй. Хэрвээ хэмжээ алдвал бага оноо авна. Ерөнхийдөө өөрийгөө маш сайн мэдрэх ёстой төрөл гэж ойлгож болохоор. Бүхий л үйлдлээ стандартын дагуу хийж гүйцэтгэж байж медаль хүрдэг. Тэнцвэрээ алдах юм бол медальгүй хоцорно. Сүүдэр тулаан гэхээр өөрийнхөө өмнө нэг хүн байна гэж төсөөлөөд л тулалдана гэсэн үг. Тэр утгаараа их өвөрмөц байдаг юм.

-Хятадын нээлттэй тэмцээн чиний оролцсон хэд дэх том тэмцээн бэ. Өмнө нь ямар тэмцээнд оролцож байв?

-Улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түрүүлж байсан. Мөн Орост болсон "Байгаль цом" тэмцээнд оролцож, түрүүлж байлаа. Сая оролцсон Хятадын нээлттэй тэмцээн бол Олон улсын хэмжээний хоёр дахь тэмцээн байсан.

-Олон улсын тэмцээнд оролцоод, гадаадын тамирчинтай тулалдах ямар байдаг вэ. Монголын тамирчдаас илүү чадвартай юу?

-Орост тэмцээнд оролцоход тулалдаж байсан тамирчдын ур чадвар Хятадын тамирчдынхтай ойролцоо санагдсан. Харин Монголын тамирчдын ур чадвараас огт өөр санагдаж байлаа. Илүү чадварлаг, хүчтэй байдаг юм.

-Чиний цаашдын хамгийн том зорилго юу вэ?

-Дэлхийн аварга болохыг хүсдэг.

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +15
Шөнө +7

Нөгөөдөр

Өдөр +17
Шөнө +5

Өдрийн зурхай



Аргын тооллын:

2016 оны 08-р сарын 23,
Мянгар гараг

Билгийн тооллын:

Шинийн 20 урсаан цагаан
лэнгэтэй Улаагчин үхэр өдөр.
Ангааг гараг

Наран ургах/шингэх:

07:01 / 20:51

Үс засуулбал:

Өлсөж ундаасна.

Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, мал арилжих, бут дарах, газрын ам бооход сайн. Байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Халуун эгэх улирал 1 цаг 36 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



Америкийн хамгийн залуу олимпийн аварга

Америкийн чөлөөт бөхийн тамирчин Кайл Снайдер Риогийн олимпийн сүүлчийн өдрийн чөлөөт бөхийн барилдаанд түрүүлж, анхны олимпийн алтан медаль хүртлээ. Ингэснээр эдүгээ 20 настай тэрбээр АНУ-ын түүхэн дэх хамгийн залуу чөлөөт бөхийн олимпийн аварга болж байна. Чөлөөт


бөхийн эрэгтэй 97 кг-ийн жинд Снайдер алтан медалийн төлөө Азербайжаны бөх Хетаг Гозюмовтай барилдаж, 2:1-ын харьцаатайгаар ялалт байгуулсан. Түүний хувьд хүнд жинд Олимпийн алтан медаль хүртсэн АНУ-ын хоёр дахь бөх болж буй. Өмнө нь Лондонгийн олимпод Жейк Варнер энэ жинд аваргалж байсан юм.

Усэйн Болт "зодог тайлж" магадгүй

Дэлхийн хамгийн хурдан хүн гэгддэг Ямайкийн гүйлтийн суут тамирчин Усэйн Болт зодог тайлж магадгүй нь. Тэрбээр Олимпийн 16 дахь өдөр эрэгтэйчүүдийн 4x100 м-ийн буухиа гүйлтэд алтан медаль хүртсэн. Ингэснээр Болт Риогийн Олимпоос гурав дахь алтан медаль, Олимпоос нийтдээ ес дэх алтан медаль хүртсэн юм. Болт үүний өмнө Риогийн Олимпын 100 болон 200 метрт түрүүлээд байсан бөгөөд тэрбээр 100, 200 болон 4x100 м-т гурвууланд нь түрүүлэн "Бээжин-2008" болон "Лондон-2012"-ын амжилтаа давтсан. Гэвч 31 дэх зуны олимп түүний хувьд сүүлчийн

олимп байж мэдэх аж. 2013 оноос хойш Болт маш олон хэвлэлд Риогийн олимп түүний хувьд сүүлчийнх нь хэмээн ярьж байсан юм. Түүнчлэн, 2017 онд Лондонд болох Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд уралдсаныхаа дараа тэтгэвэртээ сууна гэдгээ мэдэгдэж байв. Харин тэр үе нь эдүгээ иржээ. Гэхдээ 2020 оны долдугаар сарын 24-ний өдөр Үндэсний олимпийн цэнгэлдэхэд албан ёсоор нээлтээ хийх Токиогийн олимпоор Усэйн Болт эргэн ирж ч магадгүй. Эсвэл үгүй ч байж болох юм. Хэрэв Усэйн Болт ирэх онд зодог тайлвал Токиогийн олимп тун ч сонирхолгүй болж мэдэх нь.

ТЭНГИС КИНО ТЕАТР



Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиллагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онцноцтой гэмт хэрэгтнүүдэд оршоол үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.



УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.